



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар A/334

Морон сум

Барилгын засварын ажил хүлээж авах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48,6 Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын их засварын ажил хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Х.Даваасүрэн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Д.Мягмарсүрэн

(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

Д.Аюушжав

(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчиний хяналтын улсын байцаагч)

Ж.Нацагдорж

(Аймгийн онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

Д.Сүхээ

("Хөвсгөл ус суваг"ХХК-ийн Ерөнхий инженер)

Ш.Нямханд

("Хөвсгөл дулааны станц"ТӨХК-ийн Ерөнхий инженер)

Ж.Улаанбаатар

("Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв "ОНӨААТҮГазрын хяналтын инженер")

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Н.Ууганцэцэг ("Итгэлт чандмань" ХХК-ийн Захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д.Дарьбаатар ("Бунбах" ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Б.Батжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга )

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилгын засварын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын засварын ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилгын засварын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

